



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”**

2018 оны 3 дугаар сар

Агуулга

Агуулга

Аудитын нэр, код

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт

Аудитын хамрах хүрээ

Үндсэн мэдээлэл

Эрсдлийн үнэлгээ

Аудитын арга зүй

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудит хийх хугацаа

Аудитын хөтөлбөр

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

Хавсралт №1 Эрсдэлийн үнэлгээ

Хавсралт №2 Асуудлын шинжилгээ

Хавсралт №3 Аудитын арга зүй

Хавсралт №4 Аудитын хөтөлбөр

Хавсралт №5 Үр өгөөжийн төлөвлөлт

Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор

БАТЛАВ

П.Төвсанаа

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



1. Аудитын нэр:

“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”

2. Аудитын код:

ГАГ-ДУА-2018-01-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан аудитын сэдвийн төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт:

“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитой тооцож, үнэлсэн эсэх.

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитад орон нутгийн төсвөөс 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын 21 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааг хамруулна.

6. Үндсэн мэдээлэл

Дундговь аймгийн ИТХ-ын 2016 оны 12 сарын 02-ны өдрийн “Аймгийн 2017 оны төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй харин 2017 оны 04 сарын 25-ны өдрийн “2017 оны орон нутгийн төсөвт өөрчлөлт оруулах тухай” 15 дугаар тогтоолоор 520.2 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, мөн 2017 оны 11 сарын 15-ны өдрийн “2017 оны орон нутгийн төсөвт өөрчлөлт оруулах тухай” 24 дүгээр тогтоолоор 615.4 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр өөрчлөн баталсан байна.

2017 онд 21 төсөл, арга хэмжээ хэрэгжиж 527.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нийт санхүүжилтийн 172.7 сая төгрөг буюу 32.7 хувийг автомашин, мотоцикл, сэлбэг хэрэгсэл худалдан авахад, 197.6 сая төгрөг буюу 37.4 хувийг барилга, барилгын засвар, тохижилтын ажилд, 157.5 сая төгрөг буюу 29.9 хувийг бусад төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

7. Эрсдэлийн үнэлгээ:

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв. (Эрсдэлийн үнэлгээг хавсралт 1-ээс үзнэ үү.)

8. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна. (Асуудлын шинжилгээг хавсралт 2, аудитын арга зүйг хавсралт 3-аас үзнэ үү).

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- ❖ Барилгын тухай хууль;
- ❖ Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- ❖ Дундговь аймгийн 2017 оны батлагдсан төсөв, түүнд орсон өөрчлөлтүүд;
- ❖ Төсвийн тухай хууль;
- ❖ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ❖ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ❖ Төрийн албаны тухай хууль;

- ❖ Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- ❖ Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”.

12. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

- Аудитын явцыг хянан удирдах ажилтан:

Тэргүүлэх аудитор П.Төвсанаа
Аудитын менежер Х.Наранцацрал

- Аудит хийх аудиторууд:

Ахлах аудитор Ч.Бэрхсайхан
Аудитор Д.Должинсүрэн

13. Аудитын хугацаа:

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 26-нд эхэлж, 2018 оны 04 дүгээр сарын 30-нд дуусгана.

14. Аудитын хөтөлбөр:

Аудитын хөтөлбөрийг хавсралт №4-д үзүүлэв.

15. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, байгууллагын санал, хавсралт гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг аудитын зорилт тус бүрээр гаргана.

Аудитын тайлангийн төслийг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авах бөгөөд тайлангийн эцсийн хувилбарыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэдэх Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулна.

14. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:

а. Боловсон хүчин: Аудитын менежер-1, гүйцэтгэлийн аудитын алба-2, нийт 3 хүн, 20 өдөр 60 хүн/өдөр

б. Санхүүгийн нөөц, бүгд: 3,532.3 мянган төгрөг.

Үүнээс:

- Цалин хөлс 2,400.0 мянган төгрөг
- Дотоод томилот 360.0 мянган төгрөг.
- Тээврийн зардал 763.3 мянган төгрөг.

в. Техник, хэрэгсэл: компьютер, зөөврийн компьютер, принтер, диктафон,
гэрэл зургийн аппарат, видео камер, хувилагч, скайнер,

Аудитын төлөвлөгөөг

Хянаж зөвшөөрсөн:

Х.Наранцацрал



Аудитын менежер

Боловсруулсан:

Ч.Бэрхсайхан



Ахлах аудитор

Д.Должинсүрэн

Аудитор

2018 оны 03 дугаар сарын 21-ний өдөр

Асуудлын шинжилгээ

